

**ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН “АРЬС ШИР” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009.02.16

2008 оны жилийн эцсийн байдлаар

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Яам, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн хийв.

Д.д	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл								
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо	Хөтөлбөрийг Засгийн газрын 2001.05.23-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан.								
2	Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа	2001-2010 он								
3	Хөтөлбөрийн зорилго	Хөтөлбөрийн зорилго нь арьс, ширний үйлдвэрийн салбарын хөгжлийн эрхэм зорилго, хөгжлийн стратегитай уялдуулан хүч чадлын ашиглалтыг дэс дараатай нэмэгдүүлж, салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.								
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	<table border="1"> <tr> <td data-bbox="443 880 564 1429">Зорилтууд</td> <td data-bbox="564 880 1473 1429">Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: а/ Түүхий эдийн чанарыг сайжруулах; б/ Түүхий эд бэлтгэлийг ноос, ноолуур, мах боловсруулах салбарын үйлдвэрүүдтэй хоршин зохион байгуулж, Бөөний худалдаа сүлжээгээр түүхий эд бэлтгэх систем тогтоох; в/ Үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, тогтвортой ажиллагааг хангах эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх; г/ Салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, түүхий эдийн боловсруулалтын төвшинг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн шаардлагад нийцүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах; д/ Байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.</td> </tr> <tr> <td data-bbox="443 1429 564 1552">2001 - 2003 он</td> <td data-bbox="564 1429 1473 1552">Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, боловсруулах үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэн үйлдвэрлэлийг хэвийн өсөлттэй явуулах нөхцлийг бүрдүүлэх.</td> </tr> <tr> <td data-bbox="443 1552 564 1675">2004 - 2006 он</td> <td data-bbox="564 1552 1473 1675">Түүхий эд, хагас бэлэн бүтээгдэхүүний боловсруулалтын төвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэс дараатай нэмэгдүүлэх.</td> </tr> <tr> <td data-bbox="443 1675 564 1859">2007 - 2010 он</td> <td data-bbox="564 1675 1473 1859">Арьс, ширэн түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн төвшинд хүргэх, байгаль орчинд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлж, салбарын хөгжлийн стратегийн эрхэм зорилгыг хангах.</td> </tr> </table>	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: а/ Түүхий эдийн чанарыг сайжруулах; б/ Түүхий эд бэлтгэлийг ноос, ноолуур, мах боловсруулах салбарын үйлдвэрүүдтэй хоршин зохион байгуулж, Бөөний худалдаа сүлжээгээр түүхий эд бэлтгэх систем тогтоох; в/ Үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, тогтвортой ажиллагааг хангах эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх; г/ Салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, түүхий эдийн боловсруулалтын төвшинг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн шаардлагад нийцүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах; д/ Байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.	2001 - 2003 он	Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, боловсруулах үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэн үйлдвэрлэлийг хэвийн өсөлттэй явуулах нөхцлийг бүрдүүлэх.	2004 - 2006 он	Түүхий эд, хагас бэлэн бүтээгдэхүүний боловсруулалтын төвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэс дараатай нэмэгдүүлэх.	2007 - 2010 он	Арьс, ширэн түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн төвшинд хүргэх, байгаль орчинд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлж, салбарын хөгжлийн стратегийн эрхэм зорилгыг хангах.
Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: а/ Түүхий эдийн чанарыг сайжруулах; б/ Түүхий эд бэлтгэлийг ноос, ноолуур, мах боловсруулах салбарын үйлдвэрүүдтэй хоршин зохион байгуулж, Бөөний худалдаа сүлжээгээр түүхий эд бэлтгэх систем тогтоох; в/ Үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, тогтвортой ажиллагааг хангах эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх; г/ Салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, түүхий эдийн боловсруулалтын төвшинг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн шаардлагад нийцүүлэх замаар үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлж, салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах; д/ Байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх.									
2001 - 2003 он	Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, боловсруулах үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлэн үйлдвэрлэлийг хэвийн өсөлттэй явуулах нөхцлийг бүрдүүлэх.									
2004 - 2006 он	Түүхий эд, хагас бэлэн бүтээгдэхүүний боловсруулалтын төвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэс дараатай нэмэгдүүлэх.									
2007 - 2010 он	Арьс, ширэн түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний чанарыг олон улсын зах зээлийн төвшинд хүргэх, байгаль орчинд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар өрсөлдөх чадварыг дээшлүүлж, салбарын хөгжлийн стратегийн эрхэм зорилгыг хангах.									

5	Хүлээгдэж буй үр дүн	Хөтөлбөрийн нэг ба хоёрдугаар шатны зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ. а/ арьс, ширний салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2004 он гэхэд 1999 оныхоос дунджаар 24.0 хувиас доошгүй өсөх; б/ боловсруулсан арьс, шир, бэлэн бүтээгдэхүүний экспорт 2004 онд 1999 оныхоос 30, улсын нийт экспортод тус салбарын эзлэх хувь 38 хувиас доошгүйгээр тус тус нэмэгдэх;									
		в/ боловсруулах үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт 27.6, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт 20.0 хувиар өсөж, салбарын хэмжээнд ажилгүйдэл 23.8 хувиар буурах.									
6	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийт зардал/	1420.9 сая төг								
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	ШУТ-ийн сангаас 67.0 сая төг, улсын төсвөөс 10 сая төг, нийтдээ 77 сая төгрөг								
		тухайн жилд зарцуулсан	32 сая төгрөг								
7	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Нийт	90	80	75	70	65	40	Дундаж	
		Хөтөлбөрийн I-II шатны зорилт	5	1	3	1					80%
		Хөтөлбөрийн III шат 2007-2010 оны зорилт	5		1	1	1	1	1	1	70%
8	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл				Хувь				
	-	-	-				-				
за 9	Хөтөлбөрийн хэрэгжилт	Засгийн газрын 2001 оны 114 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл”, Үйлдвэр, худалдааны сайдын 2006 оны 140 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Арьс шир дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх III үе шатны төлөвлөгөө”-ний арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг үндэслэн хяналт-шинжилгээг хийв.									
	1. Түүхий эдийн чанарыг сайжруулах зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөсөн. III шатны 2008 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц нь 2010 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад дунджаар $(70+70) / 2 = 70$ хувьтай байна.	I, II шатанд - 80% - Арьс, ширэн түүхий эдийн бэлтгэл, аргачлалын 5 стандартыг шинээр боловсруулж, 34 стандартыг хянан шинэчилж батлуулаад мөрдөж байна. - Түүхий эдийн захын стандартыг батлан мөрдүүлж, захуудад аттестатчилал явуулжээ. - Арьс ширний экспортод хяналт тавих, мөрдөж буй техникийн зохицуулалтыг Үйлдвэр, худалдааны сайдын болон Санхүү эдийн засгийн сайдын 2003 оны 64/125 тоот хамтарсан тушаалаар баталсан. III шатанд а. Түүхий эдийн бэлтгэлийн стандартыг сурталчлах /2007-2010/ - Арьс ширний экспортод хяналт тавих, мөрдөж буй техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамтарсан уулзалт зохион байгуулж, гарч байгаа зөрчлийг засах талаар хамтран ажиллаж байна. - Салбарын хүрээнд зохиогдсон уулзалт, зөвлөгөөнд оролцогчдод түүхий эдийн бэлтгэлийн стандартын талаар мэдээлэл өгсөн. ХШҮ - 70%									

		<p>б. Түүхий эдийн захын үйл ажиллагаанд аттестатчилал явуулах /2007-2010/</p> <p>- ҮХЯ-ны ТНБД-ын 2007 оны 178 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулж, түүхий эдийн захын үйл ажиллагаанд шалгалт явуулж, цаашид авах арга хэмжээний талаар мэргэжлийн хяналтын байцаагчдын дүгнэлт гаргуулан ажилласан.</p> <p>- “Түүхий эдийн захын үйл ажиллагаанд тавих шаардлага”-стандартад оруулах нэмэлт, өөрчлөлтийг боловсруулж, СХЗҮТ-ийн Зөвлөлөөр батлуулан, мөрдүүлж эхлэв.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p>
	<p>2. Түүхий эд бэлтгэлийг мах боловсруулах үйлдвэрүүдтэй хоршин зохион байгуулах, бөөний худалдааны сүлжээгээр түүхий эд бэлтгэх систем тогтоох зорилтын хүрээнд зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөсөн.</p> <p><i>III шатны 2008 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц нь 2010 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад дунджаар (30+50) / 2 = 40 хувьтай байна.</i></p>	<p>I, II шатанд - 70%</p> <p>- “Арьс, ширний анхан шатны тордолтын сургалт, судалгаа” төслийг “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэн, хэрэгжүүлэгч-компаниудтай гэрээ байгуулав. Үүний үр дүнд 2004 оны жилийн эцсийн байдлаар 11 аймагт өссөн дүнгээр 2526.9 сая төгрөгийн ноос, ноолуур, арьс шир зэрэг түүхий эд бэлтгэсэн байна. 2005 онд 5 аймагт 1020.5 сая төгрөгийн ноос, ноолуур, арьс шир зэрэг түүхий эд бэлтгэжээ.</p> <p>- Багахангайн мах боловсруулах үйлдвэр, “Дархан мах экспо” ХК-д 1550 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгуулан, орон нутгаас мах, арьс шир бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулсан. “Дархан мах экспо”, “Мах импекс” компаниуд зарим арьс, шир боловсруулах үйлдвэрүүдтэй түүхий эд нийлүүлэх гэрээ байгуулан ажилласан.</p> <p>III шатанд</p> <p>а. Бөөний худалдааны сүлжээний түшиц компаниудын ҮХ-ны сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх; /2007-2008/</p> <p>- Дорноговь аймагт бөөний худалдааны сүлжээний үйл ажиллагаа эрхэлдэг “Амт трейд” ХХК түүхий эд худалдан авалтанд нийт 222,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн 6000 ширхэг арьс ширийг дотоодын зах зээлд бэлтгэн нийлүүлжээ.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 30%</p> <p>б. Мах боловсруулах үйлдвэрүүдтэй арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг хоршин ажиллах механизм бүрдүүлэх; /2007-2010/</p> <p>- “Мах импекс”, “Мах маркет” компаниудын мах боловсруулах үйлдвэрүүд “Дархан Нэхий” зэрэг арьс шир боловсруулах үйлдвэрүүдтэй түүхий эд худалдах, худалдан авах гэрээтэй ажиллаж байна.</p> <p>- “Мянган малчны зөвлөгөөн”-д арьс шир боловсруулах үйлдвэрийг төлөөлүүлж, үйл ажиллагаа, түүхий эдийн чанар, малчид, мах боловсруулах үйлдвэр, арьс шир боловсруулах үйлдвэрүүд хоршин ажиллах боломжийн талаар илтгэл, мэдээлэл хэлэлцүүлэв. Мах боловсруулах үйлдвэрүүдийн төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулж, хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхээр хамтран ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 50%</p>
	<p>3. Үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, тогтвортой ажиллагааг хангах эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөсөн.</p>	<p>I, II шатанд - 90%</p> <p>- “Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулсны үр дүнд орон нутагт арьс, ширэн эдлэлийн жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдсэн.</p> <p>- ЖДҮ-ийг дэмжих сангаас 880.4 сая төгрөгийн эх үүсвэр бүхий зээлийн материалыг уг санг ашиглах журмын хамт 18 аймагт хүргүүлсэн.</p> <p>- Засгийн газрын 2003 оны 188, УИХ-ын 2003 оны 54 дүгээр тогтоолуудаар орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг</p>

	<p><i>III шатны 2008 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц нь 2010 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад дунджаар (70+90) / 2 = 80 хувьтай байна.</i></p>	<p>баталж гаргалаа.</p> <ul style="list-style-type: none"> - Арьс шир боловсруулах чиглэлийн үйлдвэрүүдийн тоо 1989 онд 13 байсан бол 2005 онд 66 болж өссөн. Эдгээрээс 38 нь тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. 1999 онд сул зогсож байсан Дарханы нэхий эдлэлийн үйлдвэрийн хүч чадлын ашиглалт 40.0 хувьд, хүч чадлынхаа 1.9 хувийг ашиглаж байсан “Булигаар” ХК-ийн хүч чадлын ашиглалт 34.0 хувьд, хүч чадлынхаа 0.2 хувийг ашиглаж байсан “Монгол шевро” ХК-ийн хүч чадлын ашиглалт 15.0 хувьд тус тус хүрчээ. - Туркийн “ЭКСИМ” банкны зээлээр арьс ширний үйлдвэрийн парк байгуулах төслийг хэрэгжүүлэхээр Засгийн газар хоорондын комисс “...ойлголцлын баримт бичиг” гарын үсэг зурсан. - Арьс ширний үйлдвэр технологийн паркийн эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор “Үйлдвэрлэл технологийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-д өргөн барихаар зохих журмын дагуу бэлтгэсэн. <p><i>III шатанд</i></p> <p><i>а. Хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, хууль, эрх зүйн мэдээлэл, зөвлөлгөө өгөх үйлчилгээнд хамруулах, /2007-2010/;</i></p> <ul style="list-style-type: none"> - Арьс ширний салбарын тулгамдсан асуудлуудаар “Арьс ширний салбарын үндэсний зөвлөгөөн” зохион байгуулж, хэлэлцэв. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг “Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөн”-ий бичиг баримт, ЗГ-ын 2008 оны 191-р тогтоолд тусгуулсан. - Салбарын үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн хүсэлтээр хууль тогтоомж, хууль, эрх зүйн мэдээлэл, зөвлөлгөө өгч байна. 2008 онд давхардсан тоогоор 104 аж ахуйн нэгж, 425 хүнд албан бичгээр болон амаар зөвлөгөө өгсөн. ХШҮ - 70% <p><i>б. Үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангахад нөлөөлөх хүчин зүйлүүдийн судалгаа хийх, /2007/;</i></p> <ul style="list-style-type: none"> - Арьс ширний үйлдвэрлэлийн цогцолборын хүрээнд арьс ширний судалгаа туршилтын үндсэн чиглэлийн талаар салбарын инженер, эрдэмтэдтэй ярилцлага зохион байгуулж, “Арьс ширний үйлдвэрлэлийн чиг хандлага” сэдэвт илтгэлийг хэлэлцүүлэв. - Үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, тогтвортой ажиллагааг хангахад нөлөөлөх хүчин зүйлүүд, эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр судалгаа явуулан “Арьс ширний салбарын стратегийн хөтөлбөр” боловсруулах зөвлөх үйлчилгээний нээлттэй тендерийг зохион байгуулж, “Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулав. ХШҮ - 90%
	<p>4. Салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд 4 арга хэмжээ төлөвлөсөн.</p>	<p><i>I, II шатанд - 80%</i></p> <ul style="list-style-type: none"> - “Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт” төслийн I-II шатанд “Дархан нэхий” компанийн боловсруулах үйлдвэрт “менежмент, технологийн шинэчлэл” төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Уг төслийн II шатанд “Булигаар”, “Шевро”, “Сутайн дэвшил” зэрэг 8 аж ахуйн нэгж хамрагдан шинэ технологи нэвтрүүлэх туршилт судалгаа хийжээ. - 2006 оны эхний хагас жилийн байдлаар Италийн хөрөнгө оруулалтаар хоногт 182 хос гутал үйдвэрлэх хүч чадалтай үйлдвэр ашиглалтад оруулж, 300 хүнийг ажлын байртай болгосон. - “Армона” корпорацийн Арьс судлалын эрдэм шинжилгээний

	<p><i>III шатны 2008 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц нь 2010 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад дунджаар $(70+70+70+50) / 4 = 65$ хувьтай байна.</i></p>	<p>төвд ШУТ-ийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр “Арьс, ширэн түүхий эдийн бүтэц, шинж чанарын онцлогт зохицсон, байгаль орчинд халгүй технологи бий болгох” төслүүдийг боловсруулан хэрэгжүүлжээ.</p> <ul style="list-style-type: none"> - Салбарын үйлдвэрүүдийг үзэсгэлэн яармагт жил бүр оролцуулдаг. Үүний үр дүнд үйлдвэрүүд түншийн харилцаа тогтоож бүтээгдэхүүнээ сурталчлах, экспортлох, химийн материал, тоног төхөөрөмж, сэлбэг импортлох гэрээ байгуулан ажиллаж байна. - 2006 оны эхний хагас жилд тус яамны Хөнгөн үйлдвэрийн газраас “Арьс ширний үйлдвэрлэлийн цогцолбор төсөл”-ийн үзэл баримтлалыг боловсруулж, Үйлдвэр, худалдааны сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. <p>III шатанд</p> <p>а. Салбарын зарим үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник технологийн чиглэлээр сургалт семинар, зөвлөлгөөн зохион байгуулах; /2007-2008/</p> <ul style="list-style-type: none"> - Салбарын зарим үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник технологийн чиглэлээр сургалт семинар, зөвлөлгөөн зохион байгуулсан. “Арьс ширний үйлдвэрлэлийн салбарын чанарын хяналт”, “Итгэмжлэгдсэн лабораторийн чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт олон улсын семинариудад салбарын эрдэм шинжилгээний төвийн төлөөлөгчдийг оролцуулав. Мөн Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэх эко-технологи, “Арьс ширний салбарын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн асуудал”, Арьс ширний үйлдвэрлэлийн салбарт хөдөлмөр эрхлэлт, Үйлдвэрлэл технологийн паркийн асуудлаар сургалт семинарууд удаа дараа зохион байгуулж, үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулав. <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p> <p>б. мэргэжилтэй ажилчин бэлтгэх давтан сургах тогтолцоо бүрдүүлэх, сургалтыг эрчимжүүлэх; /2007-2008/</p> <ul style="list-style-type: none"> - “Арьс ширний үйлдвэрийн салбарт мэргэжилтэй ажилчин бэлтгэх давтан сургах тогтолцоо бүрдүүлэх, сургалтыг эрчимжүүлэх хэрэгцээ” сэдэвт илтгэлийг хэлэлцүүлэв. Арьс ширний салбарын ажилчдад ур чадвар дээшлүүлэх, инженер техникийн ажилтнуудад технологийн менежментийн чиглэлээр тус тус сургалт зохион байгуулж, салбарын үйлдвэрүүдийн 30 хувийг хамруулаад байна. - ҮАБЗ-д “Арьс ширний салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд, шийдвэрлэх арга зам”-ын талаар танилцуулга, шийдвэрийн төслийг хүргүүлсний дүнд мэргэжилтэй ажилчин бэлтгэх давтан сургах тогтолцоо бүрдүүлэх, сургалтыг эрчимжүүлэх асуудлаар ЗГ-ын 2007 оны 9-р сарын 19-ний өдрийн хуралдааны 44-р тэмдэглэл гаргуулж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар ажлын хэсэг байгуулан ажиллав. <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p> <p>в. салбарын үйлдвэрүүд техник технологи шинэчлэх төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; /2007-2010/</p> <ul style="list-style-type: none"> - Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтад эцсийн бүтэгдэхүүний үйлдвэрлэлийг хамруулж, Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор батлуулан, хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжид орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлж байна. - “Чингисийн чулуу”, “Дархан Нэхий”, “Армоно” корпораци,
--	--	--

		<p>“Харгиа” ХК-иудын техник технологио шинэчлэх төслийг боловсруулахад нь дэмжлэг үзүүлж, олон улсын хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлэхээр хандаад байна.</p> <p>- “Арьс ширний үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламж”-ийг шинээр барьж байгуулах талаар Чех улсын Акваконсалтинг консорциумын ажилтнуудтай хийх уулзалтыг зохион байгуулав. Чехийн тал 22 сая ам.долл-ын хөрөнгө оруулалт бүхий төслийн урьдчилсан тооцоог ирүүлжээ. Үүнтэй холбогдуулан санхүүжилтийг шийдвэрлүүлэх талаар санал боловсруулж ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр СЯ-нд хүргүүлэв.</p> <p>- “Дархан нэхий” ХК-ийн Үйлдвэрийн хаягдал цэвэрлэх байгууламжийн төсөл Чех улсын буцалтгүй тусламжийн хүрээнд амжилттай хэрэгжин дуусах шатанд явагдаж байна.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p> <p><i>г. өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, шинэ зах зээлд гарахад нь таатай нөхцөл бүрдүүлэх; /2007-2010/</i></p> <p>- Салбарын үйлдвэрүүдийг өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, шинэ зах зээлд гарахад нь таатай нөхцөл бүрдүүлэх ажлын хүрээнд Европын холбооны Тарифын хөнгөлөлтийн ерөнхий систем, Бараа бүтээгдэхүүнийг газарзүйн заалтад хамруулах чиглэлээр сургалт семинар зохион байгуулж салбарын үйлдвэрлэгчдийг өргөн хамрууллаа.</p> <p>- “Монголд үйлдвэрлэв”, “Арьс ширэн эдлэл-2007” үзэсгэлэн худалдааг тус тус зохион байгуулж, салбарын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлан, тэргүүний зохион бүтээгч, үйлдвэрлэгчдийг шагнаж урамшууллаа.</p> <p style="text-align: right;">ХШҮ - 50%</p>
	<p>5. Байгаль орчин хүний эрүүл мэндэд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээ төлөвлөсөн.</p> <p><i>III шатны 2008 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц нь</i></p>	<p><i>I, II шатанд - 80%</i></p> <p>- Цэвэр үйлдвэрлэлийг нэвтрүүлэх “Туул-21” төсөлд “Монгол шевро”, “Дархан нэхий” ХК-уудыг хамруулан цэвэр үйлдвэрлэлийн үнэлгээний завсрын тайланг гаргаж, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд Цэвэр үйлдвэрлэлийн зарчмыг нэвтрүүлээд байна. Үйлдвэр, худалдааны яам, Байгаль орчны яам хамтран МХАҮТанхим дээр “Цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төв”-ийг байгуулан, холбогдох судалгаа, шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллажээ. 2006 оны байдлаар шинээр 2-3 үйлдвэрт цэвэр үйлдвэрлэлийн механизмыг хэрэгжүүлэх үнэлгээг хийж байна.</p> <p>- Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран ажилласны үр дүнд 2000 оны төвшинтэй харьцуулбал арьс ширний үйлдвэрүүдэд ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартыг мөрдүүлэх ажилд ахиц өөрчлөлт гарч байна. “Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага” стандартыг боловсруулж батлуулав. 2006 оны байдлаар, Үйлдвэр, худалдааны яамны Хөнгөн үйлдвэрийн газар, Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран, MNS-5480:2005 стандартын хэрэгжилтийн төвшинг тогтоох улсын үзлэгийг хангалттай сайн зохион байгуулсан. Улсын хэмжээнд 2006 оны байдлаар арьс шир боловсруулах нийт 38 үйлдвэр байгаа бөгөөд үүнээс 33 үйлдвэр уг үзлэгт хамрагдсан. Эдгээр үйлдвэрүүдийн 76 хувь нь мэргэжлийн технологич инженергүй байна. Эндээс арьс ширний ихэнх үйлдвэрүүдийг мэргэжлийн бус хүмүүс удирдан явуулж байна гэсэн дүгнэлт гарч байна. Стандартын үзүүлэлтийн хэрэгжилт нь дундаж төвшин 59.1 хувьтай гарч “хангалттай биш” байна. Үүнээс 5 үйлдвэр 90 хувиас дээш, 16 үйлдвэр 50-89 хувь, 12 үйлдвэр 50-аас доош хувьтай байжээ.</p>

	<p>2010 онд хүрэх үр дүнтэй харьцуулахад дунджаар $(70+90+70) / 3 = 76.7$ хувьтай байна.</p>	<p>III шатанд</p> <p>а. Цэвэр үйлдвэрлэлийн механизмыг салбарын боловсруулах үйлдвэрүүдэд нэвтрүүлэх; /2007-2010/</p> <ul style="list-style-type: none"> - Цэвэр үйлдвэрлэлийн механизмыг танилцуулах, нэвтрүүлэх арга зам, боломжийн талаар сургалт семинар зохион байгуулж, арьс шир боловсруулах үйлдвэрүүдийг бүрэн хамруулсан. Салбарын 5 үйлдвэрт цэвэр үйлдвэрлэлийн үнэлгээг явуулж, цэвэр үйлдвэрлэлийн механизмыг нэвтрүүлсэн. <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p> <p>б. Технологи дамжуулах төвийг байгуулж үйл ажиллагааг эхлүүлэх; /2007-2008/</p> <ul style="list-style-type: none"> - Эко-технологийн мэдээллийн санг бүрдүүлж, боломжит мэдээллүүдийг үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчид, судлаач, оюутнуудад хүргэж байна. - Арьс ширний дэвшилтэт технологи дамжуулах төвийг байгуулж, Зөвлөх инженерүүд, салбарын эрдэмтэд хамтын ажиллагааны хүрээнд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг эрхэлж байна. - Улаанбаатар хотод Технологи дамжуулах төвийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлээд байна. <p style="text-align: right;">ХШҮ – 90%</p> <p>в. Цэвэр үйлдвэрлэлийн үнэлгээ явуулж, байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй технологи нэвтрүүлснээр эдийн засгийн үр ашиг бий болгох загвар гаргах; /2007-2008/</p> <ul style="list-style-type: none"> - “Арьс шир боловсруулах эко-технологи”, “Арьс ширний үйлдвэрийн ажиллагсадын эрүүл мэндийн эрсдлийн судалгаа” сэдэвт онол практикийн бага хурлуудыг зохион байгуулж, асуудалд холбогдох илтгэлийг салбарын үйлдвэрлэл эрхлэгч менежерүүд, бизнэсменүүдэд хэлэлцүүлэв. - НҮБ-аас эрхлэн хэвлүүлсэн “Арьс ширний үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага” номыг орчуулж, хэвлүүлж Арьс шир боловсруулах үйлдвэрүүд, энэ чиглэлээр ажилладаг инженер техникийн ажилтнууд, багш, хяналтын байцаагч нарт тарааж өгч, холбогдох сургалтыг зохион байгуулав. - “Цэвэр үйлдвэрлэл, эрүүл ажлын байр” уралдааныг салбарын үйлдвэрүүдийн дунд зарлаж, явцын дунд сургалт, зөвлөгөө өгч, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж байна. - “Байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй технологи нэвтрүүлснээр эдийн засгийн үр ашиг бий болгох загвар” төсөл боловсруулсан. <p style="text-align: right;">ХШҮ - 70%</p>
10	<p>Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/</p>	<p>“Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл”-д тусгагдсан 5 зорилтын 13 арга хэмжээ төлөвлөгджээ. Хөтөлбөрийн эхний 2 шатны хэрэгжилт 2006 оны эцсийн байдлаар дунджаар 80 хувьтай байсан.</p> <p>Гуравдугаар шатанд хөтөлбөрийн зорилтын арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2008 оны жилийн эцсийн байдлаар дунджаар 70 хувьтай дүгнэгдэж байна.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад арьс, ширний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн болон бизнесийн таатай орчин бүрдэж байна. Арьс ширний үйлдвэрлэлийн цогцолбор төслийг боловсруулсан. Засгийн газрын 2007 оны 09 сарын 1-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэлээр Арьс ширний салбарын Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах шийдвэр гаргуулсан.</p>

		<p>Арьс ширний салбарын тулгамдсан асуудлуудыг зөвлөлгөөнөөр хэлэлцэн, гарсан зөвлөмжийг бичиг баримтад тусгуулан Засгийн газрын 2008 оны 191 дүгээр тогтоол гаргасан.</p> <p>Засгийн газрын 2008 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-д арьс ширний эцсийн бүтэгдэхүүний үйлдвэрлэлийг хамруулж, хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжид орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлж байна.</p> <p>Арьс, ширэн эдлэлийн жижиг, дунд үйлдвэрлэгчдэд санхүү, зээл, татвар, даатгалаар дэмжих эрх зүйн орчин бий болсон ч эдгээр үйлчилгээний хүртээмж бага, хүрээ нь хязгаарлагдмал тул зээл олгох механизмыг хөнгөвчлөх, зээлийн баталгаа, даатгалын тогтолцоог бүрдүүлэлтийг эрчимжүүлэх нь чухал байна.</p> <p>Арьс, ширэн түүхий эдийн бэлтгэл, аргачлалын стандартуудыг хянан шинэчлэн боловсруулан батлуулан мөрдөн ажиллаж байна. Уг стандартуудыг хэрэглэгчдэд сурталчлах ажил хийгдэж байгаа ч цаашид стандартын тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох нь зүйтэй.</p> <p>Хөтөлбөрийн үндсэн зорилтуудын нэг болох бөөний худалдааны сүлжээгээр түүхий эд бэлтгэх, бөөний худалдааны сүлжээний түшиц компаниудын Үйлдвэр, худалдааны сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа ба “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийн нэгжтэй хамтран ажиллах талаар санаачлага муутай ажиллажээ.</p> <p>Салбарын томоохон үйлдвэрүүд техник технологио шинэчлэх төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн төслийг боловсруулахад нь туслалцаа үзүүлж, уг төслийг олон улсын хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлэхээр хандсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.</p> <p>Салбарын тулгамдсан асуудлын нэг бол цэвэрлэх байгууламжийг шинэчлэх явдал юм. Арьс ширний үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламж байгуулах БНЧУ-ын 22 сая ам.долл-ын хөрөнгө оруулалтын асуудлыг Манай Засгийн газрын талаас шийдвэрлэгдэхгүй удаашралтай байна. Мөн хоёрдогч түүхий эдийг дахин боловсруулах асуудлыг шийдвэрлэхгүйгээр экологийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй.</p> <p>Мөн салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник технологийг сайжруулах чиглэлээр сургалт семинар, зөвлөлгөөн удаа дараа зохион байгуулж байгаа ч мэргэжлийн менежер, технологич ихээхэн дутагдалтай тул үйлдвэрлэл үндсэндээ урсгалаараа ажиллаж байгаа нийтлэг дутагдал аж ахуйн нэгжүүдэд байна. Мэргэжилтэй ажилчин бэлтгэх давтан сургах тогтолцоо бүрдүүлэх ажил эхлэлийн шатанд хэрэгжиж байна.</p> <p>Өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, шинэ зах зээлд гарахад нь таатай нөхцөл бүрдүүлэх талаар арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд Европын холбооны Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий системийн нэмэлт хөнгөлөлтийн хүрээнд Европын холбооны орнуудад арьс ширэн бүтээгдэхүүн экспортлох боломж нээгдсэн боловч тэдний захиалгын тоо хэмжээ бага, стандартынх нь шаардлага өндөр тул уг боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна.</p> <p>Байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилтын хүрээнд цэвэр үйлдвэрлэлийн механизмыг танилцуулах, нэвтрүүлэх арга зам, боломжийн талаар сургалт семинар зохион байгуулан салбарын үйлдвэрүүдэд цэвэр үйлдвэрлэлийн үнэлгээг явуулж, цэвэр үйлдвэрлэлийн механизмыг нэвтрүүлж эхэлснээр эдийн засгийн үр ашиг гарсан</p>
--	--	--

төдийгүй үйлдвэрлэл эрхлэгчдийн сэтгэлгээнд ч эерэг өөрчлөлт гарч байгаа боловч биотехнологи, цэвэршүүлэх технологи, нанотехнологи, инновацийн асуудал аль ч шатандаа ойлголт нимгэн, хэрэгжүүлэх асуудал яригдах шатанд байна.

Дэлхийн арьс ширний хөгжлийн чиг хандлага, Монголын арьс ширний салбарын өнөөгийн байдал, үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, тогтвортой ажиллагааг хангахад нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа явуулж, “Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн стратеги”-ийг боловсруулжээ. Уг баримт бичигт Монгол улсын арьс ширний салбарын ойрын 15-20 жилийн хөгжлийн гол стратеги, стратегийн үндсэн зарчмууд, зорилтууд, эн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлжээ. Арьс ширний салбарыг бодлогоор төвлөрүүлж, салбарыг оновчтой хэлбэрээр бүсчилэн хөгжүүлэх, салбарт шинжлэх ухаан-технологи-инновацийг эрчимтэй хөгжүүлэх, урт хугацааны хөрөнгө оруулалтын зээл тусламжаар хангах, хөрөнгө оруулалт, экспортыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээг цогцолбороор шийдвэрлэх нь зохистой тул “Арьс шир” дэд хөтөлбөрийг “Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн стратеги”-йн дагуу шинэчлэх шаардлагатай байна.

Үр дүнгийн статистик үзүүлэлт:

- **Арьс, ширний салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл** 2007 онд 7,384.0 сая төгрөг болж 2006 оныхоос 2 дахин өсч, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд 1.1 хувийг эзэлсэн бол 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2005 оны зэрэгцүүлэх үнээр өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 50 хувиар, 2006 оныхтой харьцуулахад 25 хувиар бууран, боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд 0.3 хувийг эзлэх болжээ.

2007 онд 2006 оноос арьс, ширэн гутлын үйлдвэрлэл 4 дахин, гадуур хувцасны үйлдвэрлэл 33 хувиар өссөн. Харин арьс, ширэн гутал, савхин болон үслэг хувцасны үйлдвэрлэл 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад нилээн буурсан байна.

- **Боловсруулсан арьс, шир, бэлэн бүтээгдэхүүний экспорт** 2007 онд 2006 оныхоос 0.8 хувь буурч, нийт экспортод тус салбар нь 2 хувийг эзэлсэн бол 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеийнхээс 10 хувь өсч, нийт экспортод тус салбар нь 1.5 хувийг эзэлж байна.

2007 онд боловсруулсан үхрийн ширний экспорт биет байдлаар 70, үнийн дүн 19.3 хувиар өссөн, боловсруулсан богийн арьсны экспорт биет байдлаар 7 хувиар өсч, үнийн дүн буурчээ. 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеийнхээс боловсруулсан үхрийн ширний экспорт биет байдлаар 50 орчим, үнийн дүн 40 хувиар буурсан, боловсруулсан богийн арьсны экспорт биет байдлаар 11 хувиар, үнийн дүн 5 хувиар буурсан. Мөн савхин болон үслэг хувцас, эдлэлийн экспорт ч 2008 онд нилээд их хэмжээгээр буурчээ.

- **Салбарын хөдөлмөрийн бүтээмж** 2007 онд 2005 оны зэрэгцүүлэх үнээр 20714.7 мянган төгрөг, 2008 онд 12629.5 мян. төгрөг болж өмнөх оныхоос 23 хувиар өссөн бол 2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеийнхээс 39 хувиар буурсан байна.

- Уг салбарт **ажиллагсдын тоо** 2005 онд 11029.0, 2006 онд 4908.0, 2007 онд 4669.0 болж, өмнөх оныхоос 2006 онд 55 хувиар, 2007 онд 4.8 хувиар, 2008 онд 15 хувиар буурлаа.

		<p>Зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> - Түүхий бэлтгэлийн системийг боловсронгуй болгох, бөөний худалдааны сүлжээгээр түүхий эд бэлтгэх ажлыг “Бөөний худалдааны сүлжээ” төслийн нэгжтэй хамтран зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх, - Арьс ширний экспортод хяналт тавих, мөрдөж буй техникийн зохицуулалтыг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, - Арьс ширний үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламж шинэчлэх асуудлыг шийдвэрлэх, - “Арьс шир” дэд хөтөлбөрийг “Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн дагуу шинэчлэн боловсруулах, - Арьс ширний үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлыг эхлүүлэх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх, энэ ажлын хүрээнд салбарын үйлдвэрүүдийн менежментийг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтыг шийдвэрлэх нь оновчтой, - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг оны хуваарилалт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй боловсруулах, хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгах, - Хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргахдаа хүрсэн үр дүн, шаардагдах санхүүжилтийн шийдвэрлэлт, түүний зарцуулалтын талаархи мэдээллийг тусгах.
11	<p><i>Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал</i></p>	<ul style="list-style-type: none"> - Салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд санхүү, зээл, татвар, даатгалаар дэмжих эрх зүйн орчин бий болсон ч эдгээр үйлчилгээний хүртээмж бага, зээл олгох хүрээ нь хязгаарлагдмал байна. - Засгийн газрын тогтоол, ҮХ-ны сайдын тушаалаар батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөв болон бусад эх үүсвэрээс олгох асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэгдээгүй болно.
12	<p><i>Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ</i></p>	<p>Холбогдох “аж ахуйн нэгжүүдийн хооронд стратегийн түншлэл-холбоо” тогтоож ажиллах асуудлыг судлан, Засгийн газар, яамд, холбогдох үйлдвэр, хоршоо, мэргэжлийн холбоо, орон нутгийн төрийн захиргааны байгууллага хамтын ажиллагаа, оролцоог улам сайжруулж чадвал илүү үр дүнд хүрэх боломжтой.</p>
13	<p><i>Хөтөлбөрийн талаархи яамны санал</i></p>	<ul style="list-style-type: none"> - “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийг цаг алдалгүй батлуулах, - “Арьс ширний салбарын тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн дагуу хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан батлуулах, - Арьс ширний үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламж шинэчлэх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, - Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг оны хуваарилалт, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй болвсруулах, хэрэгжилтэд шаардагдах санхүүжилтийг тодорхой тусгах, уг санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг Сангийн яам, Засгийн газарт оруулан дэмжлэг авах.

Танилцсан:

МХШҮГ-ын дарга

Л.Баяртулга

Хяналт-шинжилгээний үнэлгээ, зөвлөмж өгсөн:

МХШҮГ-ийн ахлах мэргэжилтэн

Д. Алтанлит